



*Empowered lives.
Resilient nations.*

ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛСАН “ХАРИУЦАГАТАЙ УУЛ УУРХАЙ” СЭДЭВТ СУРГАЛТЫН ТАЙЛАН



2017 он 1 сар

ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛСАН “ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ” СЭДЭВТ СУРГАЛТЫН ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Сургалтын зорилго

Хариуцлагатай уул уурхай (ХУУ) сэдэвт сургалтын зорилго нь уул уурхайн үйл ажиллагаанд оролцогч болон сонирхогч талууд, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудад хариуцлагатай уул уурхайн талаарх мэдлэгийг олгох, сургалтын хөтөлбөр, хичээлийн сэдвийн бүтэц шаардлага хангаж байгаа эсэхийг шалгаж үзэх, энэ чиглэлээр гарах сургалтын аргачилсан гарын авлагад сургалтанд оролцогчдоос санал авах зорилготой юм.

Хэрэгцээ, шаардлага

УИХ-ын 2014 онд батлагдсан “Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлого”-ын 3.3.1-д “... байгаль орчныг хамгаалах шаардлагыг хангасан, ил тод, хариуцлагатай уул уурхайн олборлох болон боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого баримтлах” гэж заасан байдаг.

Хариуцлагатай уул уурхай түүний зарчмуудын талаар иргэд болон үйлдвэрлэгчид тодорхой ойлголт байхгүй, түүнийг хэрэгжүүлэхэд баримтлах гарын авлага ч гараагүй байгаа юм. Иймд хариуцлагатай уул уурхайн тухай цогц ойлголтыг олон нийтэд түгээх, ойлгуулах чиглэлээр орон нутгийн холбогдох хүмүүсийг сургах, үйл ажиллагаандаа дагаж мөрдөх аргачилсан гарын авлагыг бий болгох шаардлага нь бидний ойрын зорилт болоод байна.

ХОЁР. СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТАЛААР

Сургалтанд оролцогчдод зориулсан хариуцлагатай уул уурхайн сургалтын гарын авлагыг эхний сургалтаас гарсан саналыг тусгаад, мөн хичээлийн лекцүүдийг гарын авлагад оруулсан өөрчлөлтийн дагуу шинэчлэн бэлтгээд энэхүү сургалтанд хэрэглэлээ.

Сургалтыг бид Өвөрхангай аймагт явуулахаар сонгон авлаа. Энэ нь дараах шалтгаантай байв:

- Тус аймагт нүүрс алтны уурхайнууд байдаг бөгөөд байгаль орчны нөхөн сэргээлтийг муу хийх, усыг бохирдуулах талаар хамгийн их асуудал дагуулдаг нутаг юм.

- Өвөрхангай аймаг төвийн бүсд хамрагддаг, өвлийн хүйтний нөхцөлд очих, ирэхэд зам харилцааны хувьд төвөгшил багатай байсан

- Сургалцагчдад зар түгээх, тэднийг орон нутгаас ирүүлэх ажлыг зохион байгуулаад өгөх, орон нутгийн, туршлагатай, найдвартай таних хүн байсан.

- Өвөрхангай аймаг “нинжа” нараар алдартай. Тиймд нинжа нарын төлөөллийг сургалтанд хамруулж үзэх бидний сонирхол байсан.

Сургалтыг Өвөрхангай аймгийн төв Арвайхээр хотын хуримын ордонд 2017 оны 1-р сарын 18, 19-нд зохион байгууллаа.

Суралцагсдын бүрэлдэхүүнд төр, үйлдвэрлэгч, ТББ байгууллагын төлөөлөл хамрагдсан байхаар төлөвлөсөн бөгөөд орон нутгийн нөхцөл байдлаас хамаарч аймгийн төвөөс 10 хүн, орон нутгаас 19 хүн Улаанбаатараас 2 хүн нийт 31 хүн оролцсон бөгөөд үүнд аймгийн МХГ-аас 1, БОАЖГ-аас 2, үлдсэн нь ТББ байгууллагын төлөөлөл байсан ба хөдөө сумдаас Уянгаас-6, Хайрхан дулаанаас-4, Нарийн тээлээс 4, Бат-Өлзийгөөс 3 хүн оролцов.

Оролцогсдод төрийн албан хаагч 12 /үүнд ИНХ дарга 5, сумын Засаг дарга, ажилтан-3, улсын байцаагч-2, БОАЖГ-н ажилтан-2 байв/ компанийг төлөөлж 5, ТББ-г төлөөлж 8, гар аргаар ашигт малтмал олборлогч иргэнийг төлөөлж 3 хүн байса бөгөөд энд 5 эмэгтэй, 26 эрэгтэй хүн байлаа. Түүнчлэн Улаанбаатар хотоос өөрийн боловсон хүчний нөөц, сургагч багшаар цаашид бэлдэх зорилгоор уул уурхайн тоног төхөөрөмжийн инженер Г.Ганбилэг, Уул уурхайн менежментийн төгсөх ангийн оюутан Ч.Билгүүн нарыг авч явж оролцуулсан болно. Оролцогчдын нэр, ажил, утасны дугаарыг 1 дүгээр хавсралтад үзүүлэв

Сургалтыг нээж Өвөрхангай аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга Т.Ариунболд, Тогтвортой хөгжлийн төлөөх Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ын тэргүүн Л. Долгормаа нар үг хэлсэн. Сургалт хөтөлбөрийн дагуу явагдав.

Сургалтанд оролцогч тус бүрд хичээлийн бүх сэдвээр буюу 18 сэдвийн пресентацыг хүний тоогоор хувиалан хавтасд хийж мөн хүн бүрийн хавтасд дэвтэр, бал, сургалтын хөтөлбөрийг хийж өглөө. Түүнчлэн хичээлд хариуцлагатай уул уурхайн голлох зарчмыг нарийвчлан заах чиглэлийг баримталсан бөгөөд асуулт хариултыг чөлөөтэй байлгаж, харилцан ярилцах хэлбэрээр явуулсан.

Сургалтаар дараах мэдлэгийг олгосон. Үүнд:

1. Уул уурхайн талаарх ерөнхий ойлголт. Үүнийг уул уурхайн ажлын үе шат болох геологи хайгуул, уурхай байгуулах, ашиглах, хаах гэсэн 4 бүлэгт хуваан заагаад, амьдрал дээр илүү чухал гэж үзэх, байнга хэрэглэгдэх мэргэжлийн ухагдахуун болох байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхөн сэргээлтийн талаарх ойлголтыг арай дэлгэрэнгүй хэмжээнд заав.
2. Хариуцлагатай уул уурхайн ойлголт түүний зарчмуудыг хэрэгжүүлэх аргачлал
3. Монголд хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд төрийн албадын үүрэг, оролцоо.

Бүлгийн ажлыг заасан хичээлээ бататгах, түүнийг амьдралтай холбон ярилцах, даалгавар өгч гүйцэтгүүлэх хэлбэрээр суралцагсдад хариуцлагатай уул уурхайн талаар суралцсан хичээлийн ойлголтыг нь гүнзгийрүүлэх зорилгоор хийлээ. Үүнийг оролцогчид харилцан ойлголцлыг бий болгох, санал солилцон хамтран ажиллах чухал ач холбогдолтой боллоо гэж дүгнэсэн. Үүгээр суралцагсад үзсэн хичээлийг бататгахаас гадна ХУУ-н зарчмын шалгуур үзүүлэлтийг хэрхэн баяжуулах талаарх санаа бодлыг нь сонсох ажил бас хийгдэв.

ГУРАВ. СУРГАЛТАД ОРОЛЦОГЧДЫН МЭДЛЭГ, ЗААХ АРГЫН УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ

Сургалтын үнэлгээг өдөр тутам сургалтын дараа оролцогчдоос сургалтын хэрэгцээ шаардлага, ач холбогдол, сургагч багш нарын ур чадвар, оролцогчдын сэтгэл ханамж, цаашид анхаарах зүйлийн талаар бичгээр нэргүйгээр авч байв. Давхардсан тоогоор санал асуулгын 41 хуудас бөглөгдсөн байна. Санал асуулгыг бөглөсөн хуудсыг хуулбарлан 2 дугаар хавсралтаар, санал асуулгын хуудсаар бөглөсөн материалыг нэгтгээд дэлгэрэнгүйгээр бичсэнийг /хүмүүсийн бичсэн байдлаар нь/ 3 дугаар хавсралтаар тус тус үзүүлэв.

Сургалтанд оролцогчдоос гарсан санал өгсөн үнэлгээнд дүгнэлт хийж үзвэл:

1. *Та сургалтаас хүсэн хүлээж байсан мэдлэг мэдээлэл, чадвараа олж авч чадсан уу?* гэсэн асуултанд 83% нь хангалттай авсан, 17% нь мэдлэг мэдээлэл олж авсан байдлаа дунд зэрэг гэж үнэлжээ. Эндээс харахад сургалт хүмүүст шинэ мэдлэг өгч чадаж байна, өөрөөр хэлбэл ХУУ-н ойлголтыг өгч байна гэж үзлээ

2. *Хичээлийн бүтэц заах аргад үнэлэлт өгүүлэхээр хичээлийн бүх сэдвийг хүснэгтлэн бичээд сэдэв бүрт түүний бүтэц, агуулга, мөн багшийн ойлгомжтой зааж чадаж байгаа талаар 1-5 баллаар үнэлгээ өгүүлэхээр асуулгыг хийсэн. Бүх хүмүүсийн өгсөн үнэлгээний дунджийг 3 дугаар хавсралтад тооцож, гарган үзүүлэв. Эндээс харахад дараах дүгнэлт хийж болно:*

- Үнэлгээг бөглөхдөө зарим хүн ажил хэрэгч бусаар хандсан байдал бөглөгдсөн материалаас харагдаж байсан. Гэхдээ ерөнхий түвшин, харьцангуй үзүүлэлт зөв гардаг.
- Хичээлийн бүтэц, агуулга, заасан байдлын дундаж үнэлгээ ерөнхийдөө 4-өөс дээш буюу 80%-иас дээш үнэлэгдсэн байгаа нь сургалтын агуулга, бүтэц нь зорилгодоо тохирч байна гэж дүгнэлээ. Харин энд уул уурхайн салбарын онцлог, уурхайн хаалт, байгаль орчны нөхөн сэргээлтийн хичээлийн бүтэц агуулгыг сайжруулах талаар бодож үзэх хэрэгтэй гэж үзлээ
- Хичээл ойлгомжтой заасан эсэхэд өгсөн үнэлгээ нь лекцийн бүтэц агуулгын үнэлгээнээс бүх сэдэв дээр өндөр тавигдсан дундаж нь 4,67 байгаа нь багш нарын хичээл заах чадамжийг өндөр үнэлж гэж үзлээ. Гэхдээ энд уул уурхайн ерөнхий ойлголт өгөх хэсэг нь хариуцлагатай уул уурхайн хэсгээсээ бага үнэлэлт өгөгдсөн байгаа нь мэргэжлийн хичээлийг мэргэжлийн хүнээр заалгах хэрэгтэй юм байна гэсэн ойлголт төрлөө. Гэхдээ мэргэжлийн хүмүүс заах нөхцөлд тэдний заах цагийг арай илүү тавих шаардлагатай байгааг тэдэнтэй хийсэн уулзалтаас ажиглагдсаныг дашрамд дурдаж байна

3. *Энэхүү сургалтаас танд хамгийн таалагдсан зүйлсийг, сэдвийг бичнэ үү* гэсэн асуултанд 24 санал бичиж ирүүлжээ. Бичсэн саналд дүгнэлт хийж үзвэл:

- Заасан сэдвүүдээс байгаль орчны нөлөөллийн үнэлгээ /14 санал өгсөн

байна/, байгаль орчны нөхөн сэргээлт /12/, уурхайн хаалт /9/, ил тод байх зарчим /8/ нь хамгийн олон тооны санал авсан, хүмүүст их таалагдсан байна. Эдгээр сэдвүүд нь орон нутагт илүү асуудал ихтэй байдаг, хүмүүсийн мэдэхийг хүсдэг, тэдний байнга тулгарч байдаг асуудлыг хөндсөн сэдвүүд байна гэж үзлээ.

- Хүн хүнд янз бүрийн сэдэв таалагдсан тухайгаа бичсэн боловч бидний заасан хичээлээс огт бичигдээгүй сэдэв үлдээгүй байгаа нь зааж байгаа хичээлүүд маань бүгд л хэн нэгэнд хүрч таалагдсан байна.
- Хүмүүст хичээлийн сэдвүүдээс гадна бүлгийн ажил хийх, үүгээр орон нутгийн асуудал, жишээн дээр суурилж харилцан ярилцахаас гадна бүх лекцийг хүн бүрт олшруулан өгсөн нь илүү таалагдсан байна. Ер нь бүлгийн ажил бидний хөтөлбөрт тавьсан цагт амжихгүй юм билээ. Тиймд дараагийн сургалтыг арай урт хөтөлбөрөөр явуулах хэрэгтэй санагдсан

4. *Цаашид сургалт зохион байгуулахад анхаарах, илүү сайжруулах зүйлийн талаар танд ямар санал хүсэлт байна вэ?* гэсэн асуултанд 35 санал бичиж ирүүлжээ. Эдгээр саналд дүгнэлт хийж үзвэл:

- Сургалтыг илүү өргөн хүрээг хамруулах, төрийн байгууллагуудыг татан оролцуулах, тэдэнтэй хамтарсан сургалт явуулж байх талаар 14 санал буюу нийт саналын 40%-д илэрхийлсэн байна. Энд уул уурхай эрхлэгчид, байгаль орчны төрийн албад, байгаль хамгаалагчид, уул уурхайтай хөдөөгийн багийн иргэд, сум орон нутгийн удирдлага, ИНХ-н төлөөлөгчид, ЗДТГазар, цаашилбал цагдаа, прокурор, гар аргаар ашигт малтмал олборлогчдод сургалтыг явуулахыг нэр заан санал гаргаснаас гадна сургалтыг хөдөө уурхай дээр, уул уурхай бүхий сумын баг дээр явуулах санал тавьсан байна. Энэ нь орон нутагт уул уурхайтай холбоотой мэдлэг маш бага, түүний хэрэгцээ их, мэдлэг, мэдээллийн дутмагаас асуудал их гардаг нь харагдаж байна. Тэнд ХУУ ярихаас өмнө уул уурхайн талаарх ерөнхий мэдлэг олгох сургалт их чухал юм байна гэж үзлээ. /энэ талаар гаргасан саналыг 3-р хавсралтад хараар тэмдэглэв/
- Хүмүүс сургалтын эцсийн зорилгын талаар сайн ойлгоогүйгээс сургалтаар орон нутгийн өнөөгийн бэрхшээлийг яриулах, шийдвэрлэх арга зам, хууль эрх зүйн зохицуулалтыг шийдүүлэх хүсэл бүхий 9 саналд буюу нийт саналын 26%-д илэрхийлсэн байна. Энд сургалтын сэдвийг орон нутгийн хэрэгцээ, тулгамдаж буй асуудалтай холбох, гар аргаар ашигт малтмал олборлогчдыг яаж зохицуулахыг ярихыг хүссэн байна / энэ талаар гаргасан саналыг 3-р хавсралтад хөхөөр тэмдэглэв/.
- Бусад асуудал нь сургалтын зохион байгуулалт, заах арга болон бусад асуудлаар санал өгсөн байна. Эдгээр санал бүрийг бид бодолцон үзэх ёстой. Энд хичээл заахдаа бид слайд уншихгүйн тулд зааж буй хичээлээ бүрэн эзэмших, хичээлийг бид заагаад байх биш оролцооны аргыг хэрэглэх, харилцан ярилах хэлбэрээр хичээлээ заахад түлхүү анхаарах г.м асуудлыг бид дотроо анхаарч, дутагдлыг засан залруулж ажиллахаар ярилцаж байна. /энэ талаар гаргасан саналыг 3-р хавсралтад улаанаар тэмдэглэв/

5. *Сургалтын ерөнхий зохион байгуулалтыг үнэлнэ үү* гэсэн асуултанд 95% нь хангалттай, 5% нь дунд зэрэг гэж үнэлжээ. Энэ нь бид сургалтыг өнөөгийн явуулж буй сургалтын түвшинд, хангалттай хэмжээн явуулж байна гэж үзлээ

6. *Танай нутагт ХУУ-г хөгжүүлэхэд юу хийх шаардлагатай гэж үзэж байна* вэ гэсэн асуултанд 45 санал ирснийг эмхэтгэн дүгнэвэл:

- ХУУ-г хөгжүүлэхэд орон нутагт сургалт явуулах, оролцогч талуудыг мэдээллээр хангах, ялангуяа иргэдийг мэдлэгжүүлэх, ингэснээр тэдний идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх талаар 16 саналд буюу нийт саналын 35%-д илэрхийлсэн байна / энэ талаар гаргасан саналыг 3-р хавсралтад хараар тэмдэглэв/. Энэ нь ХУУ-г хөгжүүлэх эхний алхам болохыг тодорхойлсон нь бидний зорилготой нийцэж байна.
- Төрийн албаны хяналт, хариуцлагыг сайжруулах, хууль хэрэгжүүлэх, бодлогоор хангах талаар 17 саналд буюу нийт саналын 38%-д илэрхийлсэн байна / энэ талаар гаргасан саналыг 3-р хавсралтад хөхөөр тэмдэглэв/. Хэдийгээр уул уурхайг хариуцлагатай байлгах нь уул уурхай эрхлэгчдээс хамаарах боловч тэнд төрийн хяналт, шаардлага тавигдахгүйгээр тэр болгон өөрөө хэрэгжихгүй зүйл юм. Төрийн албад энэ үүргээ биелүүлэхийн тулд өөрсдөө хариуцлагатай, чадвартай байх шаардлагатайг энд зөв тодорхойлжээ.
- Төр, олон нийтийн байгууллага, үйлдвэрлэгчийн хамтран ажиллах шаардлагын талаар 5 санал буюу нийт саналын 11%-д илэрхийлсэн байна / энэ талаар гаргасан саналыг 3-р хавсралтад ногооноор тэмдэглэв/. Энэ асуудал тухай уурхайн түвшинд яригдахдаа ХУУ-н олон талын оролцоог хангах зарчмын хүрээнд шийдэгдэнэ гэсэн үг. Эндээс үүний хэрэгцээ орон нутагт харагдаад байгаа нь харагдлаа.
- Уул уурхай хариуцлагатай, ил тод байх тэдэнд болон орон нутагт дэмжлэг үзүүлэх шаардлагатай тухай бичсэн байна. / энэ талаар гаргасан саналыг 3-р хавсралтад улаанаар тэмдэглэв/. Энд хүмүүс ХУУ-н элементүүдийг ярьж эхэлж байгаад баяртай байна.

Бүлгийн ажил, сургалтын төгсгөлд явуулсан чөлөөт ярилцлагын үед гарсан саналууд.

Бүлгийн ажил сургалтын үед явагдсан чөлөөт ярилцлагын үеэр гарсан саналуудын талаар тоймлон бичихэд:

1. Эдгээр ярилцлагад ерөнхийдөө орон нутагт тохиолддог асуудал, бэрхшээлийн талаар хүмүүс их ярилаа. Эдгээрийг яаж шийдвэрлэж болох талаар харилцан ярилаа, зарим зөвлөгөө өглөө.
2. ХУУ-н зарчимтай холбоотойгоор ил тод байх зарчмын талаар хүмүүс саналаа хэлж байна. Бусад зарчмын талаар тэдэнд ярих хэмжээний мэдлэг дутаж байгаа юм боловчуу гэж бодогдлоо. Энэ талаар шинэ зүйл хэлсэнгүй харин зарим зүйлийг асууж, тодруулж байлаа. Орон нутгийн амьдрал, уул

уурхайтай холбоотой гардаг асуудлын талаар бид мэдээлэл олж авлаа, гарын авлагад тусгачихаар шинэ санаа гарсангүй.

Энэ удаагийн сургалтын ач холбогдол

Өвөрхангай аймагт ХУУ-н сургалт явуулснаар тодорхой хүрээний иргэдэд уул уурхайн, ХУУ-н мэдлэг олгосноос гадна дараах үр дүн гарлаа.

- Сургалт явуулж буй багш нар бидний хичээл заах чадвар дээшилж байна. Уул уурхайн салбарын ерөнхий ойлголт өгөх хичээлийг болж өгвөл мэргэжлийн хүнээр заалгах нь илүү үр дүнтэй болохыг ойлгож авлаа. Хичээлийг заахдаа харилцан ярилцах хэлбэрийг түлхүү хэрэглэх хэрэгтэйг бас ойлголоо.
- Хичээл заах явцдаа болон суралцагсдын хэлсэн ярьсан зүйлсээс гарын авлагадаа бага ч болов зарим нэг өөрчлөлт оруулах санаа үүслээ.
- Сургалтын хөтөлбөртөө бүлгийн ажлын цагийг нэмэх нь илүү үр дүнтэй болохыг мэдэрч хөтөлбөртөө зарим нэг өөрчлөлт оруулах санаа төрлөө. Сургалтыг эхлэхийн өмнө бидний сургалт ямар хүрээг хамрах, ямар асуудлыг сургалтын хүрээнд ярихгүй байх талаар сайн ойлгуулахаас гадна сургалт явуулах тухай албан тоотыг аймгийн ЗДТГазарт явуулахдаа энэ талаар сайн тайлбартайгаар бичих хэрэгтэйг мэдэж авлаа.
- Хөдөө орон нутагт энэ чиглэлийн сургалт маш хэрэгтэй байгааг ахин дахин ойлгов.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Сургалтын үед хийгдсэн бүлгийн ажлын үр дүн, чөлөөт ярилцлага, нэргүй судалгааны материалыг бүлэглэн нэгтгэж, судалснаар мөн тэдгээрийг судалж байх үед нэмж төрсөн санаануудыг нэгтгэн дараах дүгнэлтэд хүрч байна:

1. Сургалтын гарын авлагыг сайжруулах талаар.

а. Олон талын оролцоог хангах зарчмын талаар бичсэн хэсэгт сүүлд нэмж оруулсан нэг зурагт схем, хууль дээдлэх зарчмын хэсэгт бичсэн нэг ишлэлийг хасах хэрэгтэй гэж үзлээ. Учир нь эдгээр нь утга агуулгын хувьд авцалдаа муутай болсон юм байна.

б. Гарын авлагын “Төгсгөлийн үг” гэсэн хэсгийг дэлгэрүүлж, гарын авлагын агуулгыг нийтэд нь харж, дахин найруулж бичих хэрэгтэй гэж үзлээ. Гарын авлагын шинэчилсэн хэсгийг өөр өнгөөр ялган будаад энэ тайлангийн **4 дүгээр хавсралт** болгон илгээв. Мөн дээрх хоёр хичээлийн презентацид зохих өөрчлөлтийг хийв.

2. **Сургалтын хөтөлбөрийн талаар.** Сургалтын хөтөлбөрийг 2,25 өдрийн хугацаанд үргэлжлэхээр шинэчлэн хийж энэ тайлангийн **5 дугаар хавсралтад** оруулав.

3. Сургалтын ажлын талаар. Уул уурхайн ерөнхий ойлголт өгөх хэсгийг цаашид мэргэжлийн хүнээр заалгаж байх үүднээс ШУТИС-ийн Геологи уул уурхайн сургуулиас 10 багшийг ХУУ-н сургагч багшаар бэлдэхээр тус сургуультай гэрээ байгуулж, гэрээний дагуу гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний төсөл боловсруулаад одоогоор талууд харилцан санал солилцох шатандаа явж байна.

4. Сургалтын үед авсан зарим зураг.





**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАРИУЦЛАГАТАЙ
УУЛ УУРХАЙН САНААЧИЛГА ТББ**